

**ДОРНОГОВЬ АЙМАГ САЙНШАНД СУМ 8-Р БАГ
“ГОВЬ” 30МВТ НАРНЫ ЦАХИЛГААН СТАНЦ
_____ БН**

(БАЙРШИЛ , НЭР)

**2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН**

(АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТЕРИЙН ДУГААР- 5708338)

ХЯНАСАН:

БОАЖЯ-ны хүрээлэн буй орчины бодлого
зохицуулалтын газрын мэргэжилтэн

_____ / П.ШИНЭЦЭЦЭГ /

БОЛОВСРУУЛСАН:

“Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн байгаль орчны ажилтан

_____ / Х.БАНЗРАГЧ /

2023 он

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Ерөнхий мэдээлэл

Станцын нэр:	“ГОВЬ” 30МВт нарны цахилгаан станц
Байгууллага :	“Дезерт солар пауэр вуан” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9019071103
Аж ахуйн нэгж байгууллагын регистрийн дугаар:	5708338
Байгууллагын хаяг:	Улаанбаатар хот – 14251 Сүхбаатар дүүрэг 1-р хороо , Сөүлийн гудамж, Сити плаза 307 тоот Утас: 976-88187720 E-mail: cd@unitedgreen.com

1.2. Станцын зорилго, ач холбогдол

Тус нарны цахилгаан станцыг барихдаа байгаль орчинд сөрөг нөлөөгүй, орчин үеийн дэвшилтэд техник, технологийн шийдлийг сонгохын зэрэгцээ Сайншандад шинээр баригдаж буй “Газрын тосны үйлдвэр” болон Сайншандын оршин суугчдын тодорхой хэсгийг цахилгаан эрчим хүчээр хангахад оршино. Түүнээс гадна, тус станцыг урт хугацаанд тогтвортой ажиллуулснаар шинэ ажлын байр бий болгох, татварын орлогоор дамжин улс, орон нутгийн төсвийг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой.

1.3. Станцын байршил, дэд бүтцийн хөгжлийн байдал

“Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Сайншандын нарны цахилгаан станц” нь байршлын хувьд Монгол орны зүүн өмнөд хэсэгт Сайншанд хотын хажууд байрлалтай. Ойролцоогоор 80 га ашиглагдаагүй талбайд нарны цахилгаан станцыг байгуулсан болно. Тус станцын талбай нь далайн түвшнээс дээш ойролцоогоор 940 метр өндөрт өргөгдсөн, Сайншанд хотоос зүүн урд зүгт 5,6 км зайд орших бөгөөд ерөнхийдөө тэгш гадаргуу дээр байрлана. Энэ нутаг дэвсгэрт өвс, ургамал маш бага, тачир ургадаг онцлогтой.

Зураг 1. “Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн “Говь “30МВт нарны цахилгаан станцын байршилыг Монгол орны газрын зураг дээр харуулбал





Зураг 2. “Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн “Сайншандын нарны цахилгаан станц”-ын байршилг сансарын зургаар харуулбал



Зураг 3. “Сайншандын нарны цахилгаан станц”-ын байршилг баруун өмнө зүгээс харуулсан бөгөөд тухайн орчны байдал


“Дезерт солар пауэр вуан” ХХК нь “Сайншандын нарны цахилгаан станц”-ыг Сайншанд хотын ойролцоо хатуу хучилттай автозамд ойр, суурин болон үүрэн холбооны бүх операторуудын үйлчилгээ авах боломжтой, дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт хэрэгжүүлсэн. Өнөөдрийн байдлаар тус цахилгаан станц нь бүрэн гүйцэд баригдан туршилт ,тохируулга хийгдэн **2020 оны 10 дугаар сарын 16** нд улсын комиссын шийдвэрээр ашиглалтад орж , үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа явуулах эрх нь нээгдсэн. Энэ үеэс эхлэн монгол улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнд өөрийн бүтээгдэхүүнээ тасралтгүй нийлүүлж байна. Одоогийн байдлаар нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажил үүргээ гүйцэтгэж өнгөрсөн 2023 онд **50 сая квт /цаг** эрчим хүчийг төлөвлөгөөний дагуу үйлдвэрлээд байна.

1.4. Станцынн хүчин чадал, төлөвлөлт, технологийн сонголт

“Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн “Сайншандын нарны цахилгаан станц”-ын хүчин чадал болон бусад гол үзүүлэлтүүдийг доорх хүснэгтээр харуулав.

Станцын гол үзүүлэлтүүд

Тодорхойлолт		Нарны цахилгаан станц
Хүчин чадал	МВт	29.568
Эрчим хүч/1 жилд	МВтц/жил	52,276
Хөрөнгө оруулалт	сая \$	75.85
Станцын талбай	м ²	714 000
Өгөөж/1.жилд	кВтц/кВ	1,768
Хувь/1.жилд	%	85.0
Загварын нийт тоо	ширхэг	110 880
Төв хувиргагчийн нийт тоо	ширхэг	40



Зураг 4. “Сайншандын нарны цахилгаан станц”-н нарны панелүүдийн ерөнхий төлөвлөлт

Тус нарны цахилгаан станцад доор дурдсан үндсэн болон туслах тоног төхөөрөмж, материал, барилга байгууламжууд байна. Үүнд:

- Тус бүр 270 Вт чадалтай - **110880 ш** нарны дэлгэц
- Нарны дэлгэцийн суурь - **1260 ком**
- Тогтмол гүйдлийн холболтын хайрцаг – **160 ш**
- Тус бүр 630 кВт-ын чадалтай - **40 инвертор**
- Тус бүр 2750 кВА чадалтай 35 кВ-ын трансформатор – **10 ш**
- Хувьсах гүйдлийн кабель – **5 км**
- Тогтмол гүйдлийн кабель – **48 км**
- Дэд станц - **1 ком**
- 35 кВ-ын таслуур - **10 ш**
- Дотор байрлах 35 кВ-ын таслуур - **8 ш**
- 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам - **13,8 км**
- Хяналт, хамгаалалтын систем – **1 ком**
- Харуулын байр – **1 ком**
- Гүний өрмийн худаг **1 ком** зэрэг орно .

2. СТАНЦЫН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Тус станцын байршил, техник, технологийн шийдэл, төлөвлөлт болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг үнэлэхдээ тухайн төслийн онцлогт тохируулан магадлан жагсаалтын аргыг боловсруулж ашигласан бөгөөд тухайн асуудлын хэр төлөвлөгдсөн байдлыг сайн, дунд, муу гэсэн байдлаар, харин сөрөг нөлөөлөл байгаа эсэх (тийм/үгүй), хэрвээ байгаа (тийм) бол сөрөг нөлөөллийн үр дагавар нь хэр болохыг бага, дунд, их гэсэн утгуудын аль тохирох дээр “х”-ээр тэмдэглэж, үнэлж дүгнэсэн болно.

Станцын байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлан жагсаалт.

Станцын байршил, шийдэл, төлөвлөлттэй холбоотой асуудлууд	Төлөвлөгдсөн байдал			Сөрөг нөлөөлөл байгаа эсэх	Нөлөөллийн үр дагавар		
	Сайн	Дунд	Муу		Сайн	Дунд	Муу
1. Станцын байршилтай холбогдох асуудал							
Өмнө нь ямар нэг төсөл хэрэгжиж байгаагүй онгон зэлүүд газарт хэрэгжих эсэх				Үгүй			
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа эсэх				Тийм	х		
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болон түүний ойр орчимд эмнэлэг, сургууль, төрийн байгууллага, орон нутгийн нийтийн үйлчилгээний барилга байгууламж зэрэг нүүлгэн шилжүүлэхэд хүндрэл учруулахуйц сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй олон нийтийн байгууллага байгаа эсэх	х			Үгүй			
Үерийн усны ам газар эсэх				Тийм		х	

Мөн үйлдвэрлэлийн осол, гал түймрээс хамгаалах асуудлуудыг тодорхой хэмжээнд төлөвлөсөн.

Станцын байршил, шийдэл, төлөвлөлттэй холбоотой асуудлууд	Төлөвлөгдсөн байдал			Сөрөг нөлөөлөл байгаа эсэх	Нөлөөллийн үр дагавар		
	Сайн	Дунд	Муу		Сайн	Дунд	Муу
2. Станцын шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал							
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх	х			Үгүй			
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх	х			Тийм			
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн	х			Тийм	х		
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	х			Үгүй			
Барилга байгууламж барих үед усны эх үүсвэр, нөөц бохирдох эсэх	х			Үгүй			
3. Төсөл хэрэгжих үеийн зарим асуудал							
Станцын үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх	х						
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх	х						
Орчныг тохьжуулах, нөхөн сэргээх төлөвлөгөө хэр тусгагдсан эсэх (хөрсжүүлэх, ургамал тарих гэх мэт)	х						

Геологийн тогтоц, физик газарзүйн онцлог, тэдгээртэй холбоотой болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ:

Тус станцын үйл ажиллагааны хүрээнд ямарваа нэгэн эрдэс баялаг ашиглах болон геологийн тогтоц, геоморфологийн төрх байдлыг өөрчлөх үйл ажиллагаа явагдахгүй тул тус станцын зүгээс тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна.

Тус төсөл хэрэгжих бүс нутаг нь аль хэдийн байгалийн үзэсгэлэн төрх байдлаа алдаж, төв суурин газрын эдэлбэр нутаг дэвсгэрт хамаарах болсон байна.

Геологийн тогтоц, геоморфологи, ландшафтад үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Болзошгүй гол сөрөг нөлөөллийн цар хүрээ, үргэлжлэх хугацаа, эрчим							
	Шууд	Шууд бус	Богино хугацааны	Урт хугацааны	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг	Нөлөөлөл байхгүй
Байгалийн геологийн тогтоцыг өөрчлөх				х				х
Байгалийн үнэт, ховор чулуу, чулуулаг, хурдас болон бусад байгалийн нөөц, баялаг ашиглах								х
Байгалийн геоморфологийн төрх байдлыг эвдэх, өөрчлөх	х			х				х
Байгалийн өвөрмөц, содон тогтоцтой хад чулуу, уул ус, намгархаг газар зэрэгт сөргөөр нөлөөлөх								х
Байгалийн үзэсгэлэнт төрх байдал өөрчлөгдөх	х			х			х	
Ландшафтын хэлбэр, төрх байдал өөрчлөгдөх				х			х	

Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ:

“Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн Дорноговь аймгийн Сайншанд суманд хэрэгжүүлсэн “Говь 30МВт нарны цахилгаан станц”-ын талбай нь хөрс газарзүйн мужлалаар Төв Азийн хөрс-био уур амьсгалын их мужийн Говийн их мужийн өргөргийн бүсшилийн хэв шинж бүхий Дорноговийн 12-р тойрогт, хуурай хээр болон говийн бүсийн зааг болох заримдаг цөлийн цайвар бор хөрсний тархалтын томоохон бүсэд хамаарах бөгөөд хөрсөн бүрхүүлийн хувьд жигд тархалттай гадаргын хэлбэр дүрс, өндөршилөөс шалтгаалан хэв шинж хувирахгүй, тэгш талархаг бүс нутгуудаар заримдаг цөлийн цайвар бор хөрс, түүний хэв шинжүүд өргөн тохиолдох бол нам дор, хотос газруудаар мараалаг, хужирлаг хөрсний хэв шинж өргөн тохиолдоно. Бүс нутгийн хувьд хөрсний механик бүрэлдэхүүнээрээ хөнгөн шавранцар, янз бүрийн байх боловч элсэрхэг хөрс зонхилно.

Хөрсний үржил шимээр ядуулаг, сайр чулуун хучаастай, хүнд шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Тус станцын талбай нь өмнө байгуулагдсан “Сайншанд салхин цахилгаан станц төсөл”-тэй ойрхон орших тул энэ төслийн бүтээн байгуулалт болон Сайншанд хотоос ойролцоох сумд, Замын-Үүдийн улсын чанартай зам руу чиглэсэн шороон замууд олноор үүсэж тус станцын талбайн хөрсөн бүрхэвчийг ихээхэн доройтолд оруулснаас гадна, хуучин ашиглаж байсан шороон замууд, энэ төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаатай холбоотойгоор шинэ замууд ихээр гарч тухайн орчны хөрсөн бүрхэвчийг нилээд талхалж, доройтуулсны дээр мөн салхи, ус гэх мэт байгалийн хүчин зүйлүүд тодорхой хэмжээгээр нөлөөлж буй байдал ажиглагдаж байна.

Цаашид тус станцын үйл ажиллагаанд ашиглаж буй машин техникийн шатах, тослох

материалын хаягдал, тоног төхөөрөмж, техник хэрэгслээс гарсан хаягдал, бохир ус, бүтээгдэхүүнийг эмх замбараагүй хаяснаас хөрс бохирдох, мөн ахуйн хог хаягдлыг ил задгай замбараагүй хаяснаар хөрсөн бүрхэвчид бохирдол үүсгэж, улмаар хорт бодис хөрс, хөрсний усаар дамжин хүн болон бусад амьд организмд сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэл байх бөгөөд тус тайланд тусгагдсан холбогдох журам, стандартын дагуу хог хаягдлыг цуглуулан хадгалж, зайлуулж устгах шаардлагатай.

Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй нөлөөллийн цар хүрээ, үргэлжлэх хугацаа, эрчим

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Болзошгүй гол сөрөг нөлөөллийн цар хүрээ, үргэлжлэх хугацаа, эрчим							
	Шууд	Шууд бус	Богино хугацааны	Урт хугацааны	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг	Нөлөөлөл байхгүй
Тус төслийг хэрэгжүүлснээр төслийн эзэмшлийн талбайн үржил шимт өнгөн хөрс устаж үгүй болох				x				x
Барилга байгууламж, машин, техник болон хүний хөл хөдөлгөөний улмаас хөрсний өнгөн хэсэг талхагдаж халцрах	x			x			x	
Төслийн үйл ажиллагааны улмаас хөрсөн бүрхэвч эвдэрч, хөрсний суулт, гулсалт үүсэж, элэгдэлд орох								x
Машин техникийн шатах, тослох материалын хаягдал, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг угаасан бохир ус зэргээр хөрс бохирдох	x			x			x	
Химийн бодис асгарах, хаягдал ус, хог хаягдлыг эмх замбараагүй хаяснаас хөрс бохирдох	x			x			x	
Ахуйн хог хаягдлыг ил задгай замбараагүй хаяснаар хөрсөн бүрхэвчид бохирдол үүсэх	x			x				x
Хорт бодис хөрс, хөрсний усаар дамжин хүн болон бусад амьд организмд сөргөөр нөлөөлөх								x
Аадар бороо, цасны шар усны үер ихээр бууж үерийн усны улмаас хөрс угаагдаж, үржил шимт давхарга багасах, хөрс элэгдэж, эвдрэх	x		x				x	

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежмент төлөвлөгөө (БОМТ) нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд станцын үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Энэ төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй. Төслийн болон түүний нөлөөллийн бүс дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд мониторинг хийж, үнэлгээ хийх шаардлагатай. Энэхүү төлөвлөгөө нь тухайн байгууллагын жил бүрийн байгаль орчин хамгаалах төлөвлөгөө боловсруулахад ашиглагдах баримт бичиг болно.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтыг цас борооны болон үерийн усыг шууд станцын хашаагаар өнгөрүүлэхэд биш, түүнийг хөв цөөрмийн тусламжтайгаар хуримтлуулан авч хөдөө аж ахуйн усан хангамжийг сайжруулан нийгмийн хариуцлагын хүрээнд зэргэлдээ орших малчдын усны асуудлыг хөнгөвчлөх явдал мөн тодорхойлж байна.



Станцын хашааны урд талаас нэвт гардаг үерийн усанд зохицуулалт хийгдэнэ гэсэн арга хэмжээ болно.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

❖ Усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөлөл

- Цас борооны болон үерийн ус станцын хашааны урд талаас нэвт гарч хөрс угааж, суурь конструцид сөрөг нөлөө үзүүлдэг байсан үзэгдлийг таслан зогсоож гадаргын усны нөөцийг нэмэгдүүлж, ХАА-н усан хангамжийн ашиглалтыг сайжруулах, өвлийн улиралд хүүхэд залуусын чөлөөт цагийг эрүүл агаарт зөв зохистой өнгөрүүлэх аятай нөхцөлийг бүрэлдүүлэн, газрын гадаргын онцлогийг ашиглан станцын хашааны өмнөд хэсэгт 1300 болон 1000м³ багтаамжтай 2ш цөөрмийг холбогдох 200м шороон далангийн хамтаар “Мандал шилтгээн” ХХК-аар **16 000 000** төгрөгөөр гүйцэтгүүлсэн нь үерийн усны менежментийг боловсронгуй болгосон чухал арга хэмжээ боллоо. Мөн ус хураах талбайн голдрилыг сувгаар тодотгож урсацын хэмжээг нэмэгдүүлсэн болно.



Станцын хашааны урд талд оршдог үерээс хамгаалах шуудууг сэтлэн урсдаг байгалийн тогтоцтой газрууд. /Далан барихын өмнөх байдал/





Үерийн ус хашааг нэвтлэн урсдаг голдрилын байршилүүд





Гүйцэтгэгчийн бригад ажлаа эхлэж буй нь.



Зүүн талын 95м далангийн эхний үеийн улны овоолгыг хийсэн байдал харагдаж байна. Үүний дараагаар овоолгыг Ковшоор тараан давтаад , хөрсийг усны зориулалтын машинаар шүршин услаж нягтруулалтыг хийнэ . Иймэрхүү шороон далан нь нийтдээ 3 үеэс бүрдэх бөгөөд улны өргөн нь 4 - 5м , оройн хэсгийн өргөн нь 0,7м , далангийн өндөр нь 3м болдог байна.



Эхний үеийн овоолгийг КОВШОор тараан давтаж байгаа нь.



Ковшоор эхний үеийн шороон овоолгыг тараан давтсаны дараагаар усаар шуршиж байгаа нь.



Усан нягтруулгын дараагаар дараагийн үеийн шороон овоолгыг эхлүүлж байгаа нь.



Шороо ачилтыг шуурхай хийж байна.



Баруун талын цөөрөм нь 1300м^3 -ын багтаамжтай бөгөөд хойт талаараа 105м урт 3м өндөр шороон далангаар хүрээлэгдсэн. Цөөрөм усаар бүрэн дүүрсэн үед далан руу урсан очиж хязгаарлагдах бөгөөд нөөцлөгдөх усны хэмжээ тодорхой хэмжээгээр нэмэгдэх боломжтой. Ус хуримтлалын талбайн урсацын голдролыг автогрейдерээр сэргээн цөөрөмд нийлүүлэгдэх усны хэмжээг ихэсгэсэн болно.

Баруун талын цөөрөм, далангийн зургууд





Баруун цөөрөм , далан руу татсан голдролын чиглүүлэгч



Зүүн талын цөөрөм нь 1000м^3 -ын багтаамжтай бөгөөд хойт талаараа 95м урт 3м өндөр шороон далангаар хүрээлэгдсэн. Үйл ажиллагааны зарчмын хувьд баруун талын цөөрөмтэй адилхан бөгөөд зөвхөн байршилынх нь хувьд баруун, зүүн гэж нэрлэсэн болно.



Зүүн цөөрмийн урсацын голдролыг чиглүүлж буй нь.



Зүүн цөөрмөөс үлдсэн усны хаялагыг станцын хашааны зүүн талын шуудуугаар шууд буулгах сувагтай холбож үерийн усны эрсдэлийг багасгаж өгсөн.



АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН, ШАЛГАЖ ХҮЛЭЭЛДСЭН АКТ

2023 оны 10 дугаар сар 18

Ажлын нэр ___ Үерийн ус тогтоох далан, цөөрмийн ажил -2ш
Захиалагч / байршил ___ “Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн харьяа “Говь” нарны
пахилгаан станц / Дорноговь аймгийн Сайншанд сум 8-р баг
Гүйцэтгэгч / хаяг ___ Дундговь аймаг Сайнцагаан сум 7-р баг Их тойруу Мандал
Шилтгээн ХХК байр

1. Энэхүү ажлын хүрээнд “Говь” нарны пахилгаан станцын хашааны урд талаас нь бороо болон аадрын ус үерлэж ихээхэн хэмжээний хохирол учруулдаг байсныг зогсоон газрын гадаргуугийн онцлогийг ашиглан 2ш цөөрмийг шороон дал ангийн хамт бүтээн байгууллаа.
2. Тухайн ажлыг 18м³-ын багтаамжтай “Howo” самосвал 4ш, 1м³-ын шанагтай экскаватор 1ш, 3м³-ын ковч 1ш, 20т-н усны машин 1ш, автогрейдер 1ш тус тус ажиллаж хуанлийн 9 хоногийн хугацаанд гүйцэтгэсэн.
3. Мөн энэ хугацаанд ажлын талбайд жолооч оператор 8 хүн, инженер техникч - 1 нийт 9 ажиллах хүчин захиалагчийн толоологч Х.Банзрагчийн хяналтын доор ажилласан болно.
4. Ажлын технологийн хувьд эхлээд цөөрөм байгуулах газраа тогтоож хөрсийг нь хуулаад ачин далангийнхаа уланд дэвсэн эхний үеийг дуусгаад шууд тэгшлэн усалгааны машинаар нягтруулалт хийсэн. Энэ маягаар дараагийн үеүдийг хийж дуусган далангийн улны өргөн 5м, оройн өргөн 0.7м, өндрийг 3 метрт тус тус хүргэсэн.
5. Баруун талын цөөрмийн багтаамж 1300м³, далангийн урт 105м
6. Зүүн талын цөөрмийн багтаамж 1000м³, далангийн урт 95м
7. Дээрх цөөрмүүдийн усан хураамжийг дээшлүүлэх үүднээс 800м чиглүүлэгчийг автогрейдерээр татсан.
8. Нийт 2800м³ газар шорооны ажлыг гүйцэтгэсэн байна.
9. Захиалагчийн зүгээс цөөрөм, далангийн ажлыг чанарын өндөр түвшинд байгалийн нөхөн сэргээлтийн хамт гүйцэтгэсэн байна гэж үзэж хүлээн авлаа.

АЖИЛ ХҮЛЭЭЛДСЭН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТОЛООЛЖ

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТОЛООЛЖ

“Дезерт солар пауэр вуан” ХХК
Ерөнхий менежер Т.Мөнх-Эрдэнэ
ОНХ менежер *[Signature]*
ХАБЭАБО *[Signature]* Банзрагч

МАНДАЛ ШИЛТГЭЭН ХХК
ЗАХИРАЛ *[Signature]*



- ❖ Станцын хашааг тойруулж 2021 онд сүүлийн удаа засварласан үерийн уснаас сэргийлэх шуудууг автогрейдерээр сэргээж тодотгох ажлыг 2023 оны 6-р сард “Товийн таван хүч зам” ХХК-аар **2 500 000** төгрөгийн санхүүжилтаар амжилттай хийлгэсэн.





Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт


EBARIMT.MN

ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000003322505000230606000001838044	Огноо: 2023-05-31
Борлуулагчийн: ТТД: 3322505	Худалдан авагчийн: ТТД: 5708338
НЭР: Говийн таван хүч зам	Нэр: Дезерт солар пауэр аюун
Хаяг: null	Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 2-р хороо, 34 БТТ
Утас: 96420707	Төв 4-р даяхар 406
Банкны нэр:	Утас:
Банкны дансны дугаар:	

Д/Д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Зам, гүүр, нүхэн гарц/туннел-ын үйлчилгээ	6742000	ш	1	2,500,000	2,500,000

Бараа, ажил үйлчилгээний үнэ:	2,272,727.27
Нэмэгдсэн өртгийн албан татвар:	227,272.73
Нийслэл хотын албан татвар:	0
Нийт дүн:	2,500,000



Хүлээн авсан: /
(гарын үсэг) (нэр)

Хүлээлгэн өгсөн: /
(гарын үсэг) (нэр)

- ❖ Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ
- ❖ Тайлант хугацаанд станцын хэмжээнд агаарт шатах тослох материалын ууршилт гаргахгүй байх, хатсан өвс, хуурай хог ил шатаахгүй байхыг мөрдлөг болгон ажиллаж ирлээ.
- ❖ Нефть боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалттай холбоотой том машины тоосжилтонд хяналт тавих тандах ажлыг системтэй хийсэн боловч энэ жилийн хувьд нарны дэлгэцийг ямар нэг хэмжээгээр бохирдуулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бууруулах зэрэг үзэгдлүүд ажиглагдаагүй болно. Сайншандын үйлдвэрлэлийн паркийн нефть боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын газар шорооны ажил нь дууссантай холбоотойгоор хүнд даацын автомашинуудаас улбаалан үүсдэг тоосжилтын их аян дууссан байна. Одоогоор нефть боловсруулах үйлдвэрийн бүх бараа тоног төхөөрөмж тээвэрлэлт нь зөвхөн засмалаар хүргэгддэг болсон учраас дахин энэ тоосжилтын сэдвийг хөндөх шаардлагагүй болсон сайн талтай байна.
- ❖ Агаарын бохирдлын хэмжээг Дорноговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лабораториор тогтоолгосон. Энэ ажиллагаанд **67 000** төгрөгийг зарцуулсан байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар, он /№ : 2023/118
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Дезерт Солар Пауэр Вуан” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б.Сумъяасүрэн /Лабораторийн техникч/
Сорьцын төрөл, тоо : SO₂-2, NO₂-2, Нийт тоос-2
Хүлээн авсан огноо : 2023.08.02
Сорьцын тодорхойлолт : Дорноговь аймаг, Сайншанд сум
Шинжилсэн огноо : 2023.11.21-11.22
Хуудасны тоо : 1

Үр дүн

№	Дээж авсан цэгийн нэр	Хүхэрлэг хий, SO ₂ мг/м ³	Азотын давхар исэл, NO ₂ мг/м ³	Нийт тоосны агууламж мг/м ³
1	Кэмп N 44°54'33.2 E 110°11'16.0	0.010	0.019	0.016
2	Инвертэрийн байгууламж-8 N 44°54'39.4 E 110°12'04.9	0.016	0.016	0.014
ЗДХ	MNS4585:2016	0.450	0.200	0.500

Шинжилгээ гүйцэтгэсэн лабораторийн техникч: Б.Сумъяасүрэн

Хянаж баталгаажуулсан УЦУОШТөвийн дарга: Т. Азбаяр



11/2/23, 10:35 AM

ХААН БАНК – ИНТЕРНЭТ БАНК

Огноо/Date: 2023.11.02 10:35:44

ХААН БАНК

Шилжүүлгийн мэдээлэл / Transaction information
Журналын/Journal No: 30635231

Системийн огноо/System Date: 2023.10.30

ДТ	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5038 067 987	ДЕЗЕРТ СОЛАР ПАУЭР ВУАН	67,000.00 MNT	1.00
/ жаран долоон мянган төгрөг /				
Кт	Банкны дугаар/Branch No 90 Дансны/Картын дугаар Account/Card Number 100060013015	Банкны нэр/Bank Name - Төрийн Сан Нэр/Name До.УЦУОШАлба	67,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
EB-Pollution and waste payment

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

❖ **Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ**

Станцын хамгаалалтын хашааны доторх талбайд тээврийн хэрэгсэл явах тогтсон нэг маршруттай болж, тухайн замыг тэмдэгжүүлэх, өөр олон салаа зам гаргахгүй байж хөрсний элэгдлээс хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Энэ арга хэмжээнд зориулан **1 301 100** төг зарцуулан анхааруулах, хориглох, заах үйлдэлийн замын стандартын 8ш тэмдэгийг бэлтгэн суурьлууллаа.



Замын тэмдэгний стандарт хөлнүүд ба захиалгат тэмдэгнүүд.





Холбогдох санхүүгийн баримтууд

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт



EBARIMT.MN

НЭХЭМЖЛЭХ

ДДТД: 000003324478000230411000001386725
Нэхэмжлэгч:
ТТД: 3324478
НЭР: ДЭЛГЭР ГАН МАЙНД
Хаяг:
Утас: 99766727
Э-Шуудан: delgerganmind@gmail.com
Банкны нэр: Капитрон
Банкны дансны дугаар: 3021023735

Хариуцагч:
ТТД: 5708338
НЭР: ДЕЗЕРТ СОЛАР ПАУЭР ВУАН
Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 2-р хороо, ,
34 БТТ төв 4-р давхар 406
Утас:
Гэрээний №:
Огноо: 2023-04-11
Төлбөр хийх хугацаа(Хоног):

Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Труба		ш	1	585,000.00	585,000.00



Бараа, ажил үйлчилгээний үнэ: 531,818.18
Нэмэгдсэн өртгийн албан татвар: 53,181.82
Нийслэл хотын албан татвар: 0.00
Нийт дүн: 585,000.00



Мөнгөн дүнг: *Нобан зуух модон тоован*
(үсгээр) болно
Захирал: *Нобан* /
Нягтлан бодогч: /

НЭХЭМЖЛЭХ № 198563

Сангийн сайдын 2017 оны 347 тоот
тушаалын хавсралт

Нэхэмжлэгч:
Байгууллагын нэр: Эйч Эс Си Ти ХХК
Хаяг: Сакура" цамхагийн 4-р давхарт, 402 тоот оффис
(HotelPlaza-гийн зүүн урд), 26-р хороо, Баян зүрх
дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 75054411
Э-шуудан: info@hsct.mn
Банкны нэр: Хаан банк
Данс: 5009 335 851
Банкны нэр: Голомт банк
Данс: 3215112720

Төлөгч:
Байгууллагын нэр: Дезерт солар пауэр вуан ХХК
Хаяг: ДОРНОД
Гэрээний №:
Нэхэмжлэх огноо: 2023-04-12
Төлбөр хийх хугацаа: 2023-04-19

#	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Үнэ
1	Замын тэмдэг 60см	7.00	102,300.00₮	716,100.00₮
			НӨАТ	65,100₮
			Нийт дүн	716,100.00₮



Хүлээн авсан: *Нобан* /
Нягтлан бодогч: *Нобан* / М.Мөнхчимэг /

Гүйлгээний утга: Нэхэмжлэхийн дугаар, регистер, компанийн нэрээ заавал бичихийг анхаарна уу.

Бэлэн бүтээгдэхүүн авсан бол Хаан банк 5009335851 энэ данс-руу төлбөрөө шилжүүлнэ үү.

Хэвлэлийн бүтээгдэхүүн авсан бол Голомт банк 3215112720 энэ данс-руу төлбөрөө шилжүүлнэ үү.

5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- ❖ Станцын хуваарьлах байгууламжийн авто зогсоолын талбайг хатуу хучилттай болгох ажлыг “Мандал шилтгээн” ХХК-аар хийлгэн өмнө нь машин техник ирж зогсоход тоос шороо босч, бороо тундасны дараа шаварт суух шахдаг байсан үзэгдлүүд бүрэн арилж тухайн талбайг хөрсний элэгдлээс ангижруулж бетонон хучилттай болгосон. Энэ ажилд **5 463 000** төгрөгийн зардал гаргасан байна.











Гүйцэтгэгчийн лого, нэр

АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН, ШАЛГАЖ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

2023 оны 10 дугаар сар 18

Ажлын нэр ___ Хуваарьлах байгууламжийн ард автозогсоол барих
 Захиалагч / байршил ___ “Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн харьяа “Говь” нарны
 цахилгаан станц / Дорноговь аймгийн Сайншанд сум 8-р баг
 Гүйцэтгэгч / хаяг ___ Дундговь аймаг Сайнцагаан сум 7-р баг Их тойруу Мандал
 шилтгээн ХХК байр

1. “Говь” нарны цахилгаан станцын Хаалттай хуваарьлах байгууламжийн ард талд 54м² талбайтай бетонон хучилттай автозогсоол байгууллаа.
2. Тухайн ажлыг 4 хоногийн хугацаанд гүйцэтгэсэн.
3. Мөн энэ хугацаанд ажлын талбарт газар шорооны гар багажтай 4 хүн, 1 техникчийн хамт захиалагчийн төлөөлөгч Х.Банзрагчийн хяналтын доор ажилласан болно.
4. Ажлын технологийн хувьд эхлээд зогсоол барих газраа хэмжээд хөрсийг нь тэгшлэн, гаднах хүрээгээр нь 75см-н урттай бродорууд 20см гүн ухаж суулгаад цементэн зуурмагаар бэхлэсэн. Үүний дараагаар цутгалтын бэлтгэл хангаж 10 – 20мм фракцтай хайрга 4 м³-г тараан байршуулаад усалгаа хийж дээр нь М-150 маркийн бетон зуурмагыг 10см зузаантайгаар цутгасан болно.
5. Энд талбай тэгшлэх, ухах, булах, зөөвөрлөх, тараах зэрэгт газар шорооны ажил нийт 13 м³ орсон байна.
6. Гүйцэтгэгчийн зүгээс бетон бүрэн хатах хугацааг 30 хоногоор тогтоосон.
7. Захиалагчийн зүгээс автозогсоол барих ажлыг чанарын өндөр түвшинд стандартын дагуу гүйцэтгэсэн байна гэж үзэж хүлээн авлаа.

АЖИЛ ХҮЛЭЭЛЦСЭН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

“Дезерт солар пауэр вуан” ХХК
 Ерөнхий инженер Т.Мөнх-Эрдэнэ
 ОНХ менежер *[Signature]* Т.Тулга
 ХАБЭА, БО ажилтан *[Signature]* Банзрагч

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

МАНДАЛ ШИЛТГЭЭН ХХК
 ЗАХИРАЛ *[Signature]*
 МАНДАЛ ШИЛТГЭЭН ХХК
 ТУСГАЙ ЗАСВАН
 ГЭЛЭГ

НХМаягт Т-1

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

НЭХЭМЖЛЭХ №

Нэхэмжлэгч: Мандал уулзун ХУК Хариуцагч: Делерт солор гелээр бонч хол
Байгууллагын нэр: Мандал уулзун ХУК Байгууллагын нэр: Делерт солор гелээр бонч хол
РД: 3429865 РД: 5208338
Хаяг: Ду Сэлэнгов Хаяг: _____
Утас: Факс: 99057621 Гэрээний № _____
Э шуудан: _____ Нэхэмжилсэн огноо: 2023.09.07
Банкны нэр: ХААХ Төлбөр хийх хугацаа: 3 хөл
Банкны дансны дугаар: 5450381097

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
	автo зoглoоц хeлч	1	5463000	5463000
				Дүн
				НӨАТ
				Нийт дүн
				5463000

Мөнгөний дүн мoвaн сoя дэрвeэ зeжyм мeрeн болно
зүрх санд захирал: _____
Нягтлан бодогч: _____



- ❖ Станцын талбайн хашаанд ногоон аяны хүрээнд мод тарьж ойн зурвас бий болгох, арчилж тордох ажлын хүрээнд талбайн баруун жигүүрээр 341 уртааш метр газарт бургас, агч, улиас төрлийн 2-3 настай 85ш суулгацыг хавар тарьж ургууллаа. Энэ суулгацуудыг мод үржүүлгийн “УБТ гарден” ХХК-аас худалдан авсан. Намрын уламжлалт мод суулгалтаар дээрх суулгацаас ургаагүй үлдсэн 14ш модыг 25ш болгон шинээр тарьсан бөгөөд нэмэлт суулгацыг аймгийн БОАЖГ-ын мод үржүүлгийн төвөөс нийлүүлэгдсэн болно. Мод үржүүлгийн ажилд **1 200 000** төг зарцуулагдсан байна.







Санхүүжилтын баримт



4/6/23, 9:52 AM

ХААН БАНК – ИНТЕРНЭТ БАНК

✉ 🖨

ХААН БАНК Огноо/Date: 2023.04.06 09:51:55

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No: 21955114

Системийн огноо/System Date: 2023.04.05

Дт	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5038 067 987	ДЕЗЕРТ СОЛАР ПАУЭР ВУАН	1,200,000.00 MNT	1.00
/ нэг сая хоёр зуун мянган төгрөг /				
Кт	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name		
	5028 715 412	УБТ ГАРДЕН	1,200,000.00 MNT	1.00

Дансны/Картын дугаар Account/Card Number

Нэр/Name

Гүйлгээний утга/Transaction description:
EB-Tree planting

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

❖ Гал түймэр

